



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, спортын ордны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/154/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Сайншанд сум 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Т.Оюунтуяа Утас: 99048991 Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	37.7	42.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,950.5	2,882.2
	Нийт хөрөнгийн дүн	2,988.2	2,924.5
	Нийт өр төлбөрийн дүн	69.8	0.7
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,918.4	2,923.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,988.2	2,924.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	470.9	396.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	383.9	391.6
	Үйл ажиллагааны үр дүн	87.0	5.3
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	87.0	5.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	2,918.4
	Тайлант оны үр дүн	0	5.3
	Эцсийн үлдэгдэл	2,918.4	2,923.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	223.2	405.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	213.7	372.4
	Үйл ажиллагааны ЦМГ	9.5	33.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0	(33.2)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	9.5	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	386.4	383.5
	Урсгал зардал	386.4	383.5
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	386.4	383.5
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	386.4	383.5
	ЭМД-ын сангаас санхүүжих		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Замын-Үүдийн Соёл, спортын ордны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Замын-Үүд сумын иргэдийг соён гэгээрүүлэх, хүүхэд залуусын авьяасыг дэмжиж, бие бялдарыг хөгжүүлэх, монгол түмний уламжлалт өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах, сэргээн нутагшуулах”.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр үр нөлөөгүй байна. Байгууллагад дотоод хяналтын ажилтан томилоогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 388.5 сая төгрөгийн 17 орлогын гүйлгээ, 147.4 сая төгрөгийн 6 зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8.3 сая төгрөгийн 1 худалдан авалтын гүйлгээг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад нийт 15 мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8.3 сая төгрөгийн худалдан авалтын 1 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 132.7 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй байна.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.1 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 2.1 сая төгрөгийн 3 зөвлөмж өгөгдөж, 5 зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн.

Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн өр авлага үүсгэсэн зөвлөмжийг биелүүлээгүй, тайлант хугацаанд дахин давтагдсан ба 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан авлагаас 4.0 сая төгрөгийн авлага, 0.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тус байгууллагын Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8.3 сая төгрөгийн худалдан авалтын 1 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 132.7 сая төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” 6 дугаар зүйлийн 6.4.4 “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”; 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 заалтыг зөрчин 6.8 сая төгрөгийн тавилга худалдан авсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант онд төсөвт байгууллага нь эд хогшил, урсгал засварын зардлаас 0.1 сая төгрөгийн цахилгааны төлбөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын ангиллаас 0.7 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. Тус байгууллагын бүтэц орон тоог Замын-Үүд сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/32 дугаарт захирамжаар баталсан ба удирдлагаас цалингийн сан, нэмэгдлүүдийг батлаагүй байна. Урамшуулал олгох тухай тушаалууд баталж, үр дүнгийн урамшуулал олгосон ч ажилтан албан хаагчдын ажлын тайлан, хурлын тэмдэглэл, үнэлгээ хийгдээгүй, улирлын ажлыг дүгнэх ажлын хэсгийг томилоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тоног төхөөрөмж дансанд 5 нэр төрлийн, 7 ш, 7.2 сая төгрөгийн анхны дансны үнэтэй, "0" үлдэгдэлтэй хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайлангийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийн дүн зөрүүтэй байгаагаас санхүү байдлын тайлангийн эхний эцсийн үлдэгдэл 2.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.
- 2.2. Өгсөн зөвлөмж: НББ-ийн үе шатуудад гүйцэтгэх ажиллагаа бүрт хяналтыг хэрэгжүүлэн үлдэгдлийг тулгах, зөрүүг залруулах.

3. Анхан шатны баримттай холбоотой асуудал

- 3.1. Илрүүлэлт: : Худалдан авалт болон зарлагаар харилцагчдад шилжүүлсэн төлбөрийг ибаримтад шивэгдсэн дүнтэй тулгалт хийхэд 63.8 сая төгрөгийн ибаримтыг дутуу оруулж, баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- 3.2. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн авч бүртгэлд тусгаж байх.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	+	+				+		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	8	2.1	-	-	-	-	5	-	3	2.1
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	8	2.1	-	-	-	-	5	-	3	2.1